

## 2020 ОНД ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Шалгаруулалтын дугаар: СХЭИЗОСШ – 20191231

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлагдсан Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмын 4 дүгээр зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн 2020 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээнд багтаан зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Оролцогч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, битүүмжлэн, 2020 оны 1 дүгээр сарын 13-ны 16 цагаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 502 тоот өрөөнд бүртгүүлж хүлээлгэж өгнө. Үүнд:

### ЭКСПОРТ

Үхрийн мах – 4150 тн

Адууны мах – 13950 тн

Дулааны аргаар боловсруулсан хонины мах – 3300 тн

Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах – 4000 тн

Дулааны аргаар боловсруулсан ямааны мах – 6000 тн

### ИМПОРТ

Хуурай сүү – 2000 тн

Үрийн улаанбуудай – 15000 тн

Хүнсний улаанбуудай – 60000 тн

Үхрийн мах 250 тн

1. Экспортлох эсхүл импортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;
2. Хуулийн этгээдийн нэр, байршил, хаяг, утас, цахим хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр;
3. Татварын өргүй болохыг нотолсон харьяалах татварын албаны тодорхойлолт;
4. Аудитаар баталгаажсан сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн хуулбар;
5. Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн имтгэмжлэл олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр;
6. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрийн байртай болохыг нотолсон мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт
7. Экспортлогч улсын үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ
8. Шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн байх
9. Хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд яамтай бодлогын гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй талаар мэдэгдсэн албан бичиг

**Сонгон шалгаруултад оролцогчийн материалыг хүлээн авах эцсийн хугацаа: 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 16 цаг 00 минут /Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй/**

Сонгон шалгаруулалтыг нээх хугацаа: 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 17 цаг 00 минут

### Хаяг:

**Монгол улс, Улаанбаатар – 13381, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын 9 дүгээр байр, Б корпус, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 5 давхарт, 502 тоот өрөө, Утас: 261962**